



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/12

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “н”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, 16.2.4, Коронавируст халдвар /Ковид/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.17, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг орон нутагт зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын дэд хэсгийн ахлагч:
А.Эрдэнэгэрэл

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:
З.Түвшинтөгс

- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дарга

Гишүүд:
Б.Мөнхсоёл

-Аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Газрын удирдлагын
хэлтсийн

О.Болд- Эрдэнэ

- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын
Геологи, уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагч

Б.Билгүүн

- Аймгийн Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн
тасгийн экологийн асуудал хариуцсан эрүүгийн
мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч

Уул уурхай бүхий сумдын Засаг дарга:

Сумдын холбогдох албан хаагчид:

C:user/albanbichig2021/tom toot A4

430800019

2. “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг зохион байгуулах, ажлын удирдамж, төлөвлөгөө боловсруулж 2021 оны 01 дүгээр сарын 20-ний дотор Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэхийг ажлын дэд хэсгийн ахлагч Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /А.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг батлагдсан удирдамж төлөвлөгөөний дагуу сумдад шуурхай, чанартай зохион байгуулж, хэрэгжилтийг ханган, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллахыг ажлын дэд хэсгийн ахлагч Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /А.Эрдэнэгэрэл/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  Ж.САЙНЦОГ

